



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ
ХАНГУУЛЖ, САНХҮҮЖИЛТ ОЛГОХ, ХӨРӨНГӨ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ
ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА

АУДИТЫН СЭДЭВ: ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН 2021 ОНЫ ХӨРӨНГӨ
ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ, ҮР ДҮН

АУДИТЫН КОД: ОРА-2022/16-13-ШТА-ТД



Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор
Ц.Нармандах

Утас: 70353888 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn

Аудитын менежер Б.Эрдэнэ

Утас: 70355805 Цахим хаяг: erdeneb@audit.gov.mn

Ахлах аудитор В.Жавзмаа

Утас: 70350757 Цахим хаяг: javzmaav@audit.gov.mn

Аудитор Б.Бямбатогтох

Утас: 70350757 Цахим хаяг: byambatogtokhb@audit.gov.mn

Эрдэнэт хот
2022 он



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2022 оны 05 сарын 06 өдөр

Дугаар А/05

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан “Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх”-ийн 2.4 дэх хэсэг, “Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам”-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын төсвийн 2021 хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн” гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.

3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, Нийслэлийн аудитын газар, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.

4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 11 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга /Д.Мөнхбат/, аймгийн Засаг дарга /С.Батжаргал/, Орон нутгийн өмчийн газрын дарга /Л.Оюунгэрэл/, ХББЗА ОНӨААТҮГ-ын захирал /Ц.Баяржаргал/, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын дарга /Д.Цолмон/-д зөвлөсүгэй.

5. Аудитын тайлангаар өгсөн зөвлөмж, албан шаардлага, тогтоосон актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 4 дүгээр улиралд гарган танилцуулахыг ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Бямбатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, тэргүүлэх аудиторов 2022 оны 05
дугаар сарын 06-ны өдрийн А/05 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

6117143690
CAAO273 9012608

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /сая.төгрөг/
Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн				
1	Орон нутгийн барьцаа хөрөнгийн данснаас 6 ТАХ-ний санхүүжилт олгохдоо 108.2 сая төгрөгийн техник хяналтын зардлыг суутгахгүй, өмнөх оны алдааг давтан гарсан.	113/04 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс	108.2
2	Улсын төсвийн 2019 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 2 ТАХ-ний гүйцэтгэгчид банкны баталгаагаар санхүүжилт олгохдоо 113.6 сая төгрөгийн техник хяналтын зардал, зохиогчийн хяналтын зардал, зураг төсвийн зардлыг суутгалгүй олгож, төсвийн дансанд төвлөрүүлээгүй.	65/01 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн ЗДТГ-ын СТСХэлтэс	113.2
3	Өмнөх онд хийсэн аудитаар аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад зөрчил арилгуулахаар нийт 5 зөвлөмж, 6,149.7 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлснийг бүрэн хэрэгжүүлсэн байх боловч 2019 онд хүргүүлсэн 2 албан шаардлагын хэрэгжилт бүрэн хэрэгжээгүй, зарим зөрчлүүд давтан гарсаар байна. ТАХ-ний санхүүжилтийг журмын дагуу олгоогүй, өмнөх оны алдааг давтан гаргасан, аймгийн ЗДТГ-ын СТСХ-ийн дотоод хяналтыг хэрэгжүүлээгүй.	110/01 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн Засаг дарга, ЗДТГ	
	ДҮН			221.4
Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн				
4	Зөвлөх үйлчилгээний 344.2 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээг биет бус хөрөнгөд бүртгээгүй байна	114/05 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Орон нутгийн өмчийн газар	344.2
5	Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг санхүүжилтийн баримттай тулган баталгаажуулахад 5 ТАХ-ний дуусаагүй, гэрээг цуцлах саналыг захиалагчид хүргүүлж, шийдвэрлэлт удааширсан.	112/03 ОРА-2022/16-13-ШТА-ТД	Аймгийн Засаг дарга, ЗДТГ	
	ДҮН			344.2
	Нийт дүн			565.6

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	3
БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭГДСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨЖ БУЙ Ч ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛАХАД АНХААРАХААР БАЙНА.....	7
А.1. Аймгийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байна. 7	
А.2. Тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, тооцоо судалгаагаар ТАХ-г төсөвлөж, батлах шаардлагатай байна.	8
БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ТОДОРХОЙ ШАЛТГААНААР БҮРЭН ДУУСААГҮЙ Ч САНХҮҮЖИЛТ ОЛГОХ, ХӨРӨНГӨ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.....	10
Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулж, хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангуулах шаардлагатай байна.	10
Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангах нөхцөл, боломжийг олгож, удааширч буй ажлуудад анхаарахаар байна.	11
Б.3 Хөрөнгө оруулалтын ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу олгож байгаа ч холбогдох дансанд хяналт хэрэгжүүлээгүй, хөрөнгийг дутуу бүртгэжээ.	13
Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч алдаа зөрчлийг давтан гаргасан байна.	14
ДҮГНЭЛТ:	14
Холбогдох байгууллагын санал:.....	16
ХАВСРАЛТУУД:.....	17

Товчилсон үгийн тайлбар

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АОУС	Аудитын олон улсын стандарт
БОАЖГ	Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИШС	Инженерийн шугам сүлжээ
МУ	Монгол Улс
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
ОНӨГ	Орон нутгийн өмчийн газар
СГСГЗ	Сэлэнгэ голын сав газрын захиргаа
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТАХ	Төсөл, арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
УИХ	Улсын Их Хурал
УДХТ	Ус, дулаан хуваарилах төв
ҮАГ	Үндэсний аудитын газар
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХББЗА ОНӨААТҮГ	“Хот байгуулалт, барилга захиалагчийн алба” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХҮГ	Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар
Эрдэнэт Ус ДТС	Эрдэнэт Ус дулаан түгээх сүлжээ орон нутгийн өмчит
ОНӨХК	хувьцаат компани

Хүснэгтийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгасан байдал	7
Хүснэгт 2	Аймгийн ИТХ-аар баталсан ТАХ-ний тоо, төсөөт өртөг, санхүүжих дүн	7
Хүснэгт 3	Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ	9
Хүснэгт 4	Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл	11

Дүрслэлийн товьёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Хөрөнгө оруулалтын төрөл	8

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, СТАНДАРТ, АРГА ЗҮЙН ТАЛААРХ МЭДЭГДЭЛ

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-г үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.
Аудитын зорилго	Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашигт улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэсэн. Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Хөрөнгө оруулалтын тогтолцоо үр нөлөөтэй эсэх; - Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний хэрэгжилт үр дүнтэй эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан зорилго, зорилт, арга хэмжээг хариуцан хэрэгжүүлэх, биелэлтийн явц, үр дүнг тооцон тайлагнах, үнэлж дүгнэх үүрэг хүлээсэн аймгийн ИТХ, аймгийн ЗДТГ, ОНӨГ, ХББЗА ОНӨААТҮГ-ын болон бусад байгууллагын баримт материалыг хамруулсан болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг АДБОУБ-аас хүлээн зөвшөөрсөн төрийн АОУС 300, 3000-д нийцүүлэн баталсан MNS 6817-5:2020 Гүйцэтгэлийн аудитын зарчим, MNS 6817-7:2020 Гүйцэтгэлийн аудитын стандарт, “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ын дагуу шалгадагч байгууллагын холбогдох албан тушаалтнуудаас тайлбар, тодруулга, судалгаа авч, шаардлагатай баримт материалд дүн шинжилгээ хийж, аудитын асуудлын шинжилгээ, аудитын загварын матриц, аудитын горимыг хэрэгжүүлэн нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.
Аудитын бүрэлдэхүүн, хугацаа	Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох, Б.Азжаргал нар 2022 оны 03 дугаар сарын 21-ний өдрөөс эхлэн 2022 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр хүртэлх хугацаанд гүйцэтгэв.
Аудитын явцад учирсан хүндрэл, бэрхшээлүүд:	Аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ, ОНӨГ-ын холбогдох мэргэжилтнүүд судалгаа, анхан шатны баримт мэдээллийн зөрүүтэй тайлагнал, ажлыг чиг үүргийн хуваарилалт оновчгүй байдал, албан хаагчдын хариуцлага зэргээс шалтгаалан судалгаа мэдээлэл авах, тулган баталгаажуулалт хийхэд хүндрэл үүссэн болно.

Ерөнхий мэдээлэл

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.2 дахь заалтын дагуу аймгийн ИТХ-ын 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 02/05 дугаар тогтоолоор 2021 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 234 ТАХ, 137 төсөл, хөтөлбөр, нийт 371 ТАХ-д 31,345.6 сая төгрөг, байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хэрэгжих 23 ТАХ, 36 төсөл, хөтөлбөрт 1,721.6 сая төгрөг, авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжих 18 ТАХ-д 1,397.9 сая төгрөгийг тус тус баталсан байна.

Дээрх тогтоолд 1 удаа нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

2021 оны 09 дугаар сарын 17-ны өдрийн 07 дугаар тогтоолоор ТАХ-г 249 болгож 25 ТАХ-ээр бууруулж, тухайн онд санхүүжих дүнг 39,088.7 сая төгрөг болгож 4,623.9 сая төгрөгөөр нэмэгдүүлжээ. Үүнээс 8,974.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 110 ТАХ нь өмнөх оноос дамжин хэрэгжсэн байна

Жаргалант сумын ЗДТГ-т 441.4 сая төгрөгийн 6 ТАХ-ний эрхийг шилжүүлж, 138 ТАХ-ний гүйцэтгэгч сонгон шалгаруулах ажиллагааг ОНӨГ зохион байгуулсан байна. Техникийн тодорхойлолт ирээгүй 1, амжилтгүй болсон 4 ТАХ-ний худалдан авах ажиллагаа 2021 онд хэрэгжээгүй байна.

Аймгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 244 ТАХ-нд аймгийн ЗДТГ болон ХББЗА ОНӨААТҮГ хяналт хэрэгжүүлсэн байна. Эдгээр ТАХ-ээс 2021 онд 215 ТАХ бүрэн хэрэгжиж, 29 ТАХ дуусаагүй байна.

Аудитын төлөвлөгөө, хөтөлбөрт заасан хугацаа, боловсон хүчний нөөц, аймгийн хөрөнгө оруулалт, ТАХ-ний жагсаалт, төсөвт өртөг зэрэгтэй уялдуулан ажлын төсөвт өртөг, байршил, шинж байдал, хэрэгжилтийн хувь, гүйцэтгэл зэргийг харгалзан нийт ТАХ-ний худалдан авах ажиллагаа, гүйцэтгэл, санхүүжилтийн материалуудыг хамруулж, аудитын дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Орон нутгийн хөрөнгө оруулалтад баталсан 9,313.8 сая төгрөгийн 172 төсөл, хөтөлбөрийг “Орхон аймагт хэрэгжүүлж буй дэд хөтөлбөр, төсөл хөтөлбөрийн хэрэгжилт, үр дүн /2020-2021 он/ ” гүйцэтгэлийн аудитаар шалгах тул хамруулаагүй болно.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ НЭГДСЭН БОДЛОГЫН ХҮРЭЭНД ТӨЛӨВЛӨЖ БУЙ Ч ТӨСӨВЛӨЛТИЙН ШААРДЛАГЫГ ХАНГУУЛАХАД АНХААРАХААР БАЙНА.

А.1. Аймгийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын ТАХ-г төлөвлөхдөө МУ-ын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтод нийцүүлж, орон нутагт хэрэгжүүлэх тэргүүлэх ач холбогдол бүхий хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, түүний үр ашгийг тооцон, хөгжлийн бодлого төлөвлөлтийн богино болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн байна.

“Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, “Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл”-ийн холбогдох заалтуудад нийцүүлэн төлөвлөсөн эсэхийг тулгахад 144 ТАХ-г нийцүүлэн төлөвлөжээ.

Хүснэгт 1. Хөтөлбөр, үндсэн чиглэлд тусгасан байдал

№	Нэр	Шууд туссан ТАХ-ний тоо	Үүнээс Ерөнхий байдлаар туссан ТАХ-ний тоо	Тусгагдаагүй тоо
1	Орхон аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр	10	129	
2	Орхон аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл		139	

Аймгийн ИТХ-ын тогтоолыг 1 удаа тодотгож, шилжих 25 ТАХ-г хасаж, төсөвт өртгийг 2,266.5 сая төгрөгөөр, тайлант онд санхүүжих дүнг 2,126.9 сая төгрөгөөр нэмсэн байна.

Хүснэгт 2. Аймгийн ИТХ-аар баталсан ТАХ-ний тоо, төсөвт өртөг, санхүүжих дүн /сая.төг/

№	ИТХ-ын тогтоол баталсан огноо, дугаар	хэрэгжих хугацаа	Аймгийн ИТХ-ын тогтоолоор баталсан			Зөрүү /өсөлт +, бууралт - /		
			ТАХ- ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	ТАХ- ний тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн
1	Аймгийн 2021 оны төсөв батлах тухай, 2020 оны 11 дүгээр сарын 30-ны өдөр, 02/05 дугаар тогтоол	шилжих	135	24,720.0	12,784.4			
		2021 он	139	18,030.4	14,667.9			
		НИЙТ	274	42,750.4	27,452.3			
2	Аймгийн 2021 оны төсөв батлах тухай, 2021 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр, 07 дугаар тогтоол	шилжих	110	22,099.6	8,974.5	- 25	-2,620.4	- 3,809.9
		2021 он	139	22,917.3	20,604.7		4,886.9	5,936.8
		НИЙТ	249	45,016.9	29,579.2	- 25	2,266.5	2,126.9

Орхон аймгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4-т “өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах” гэж заасны дагуу төсвийн шууд захирагчдын хүсэлт, холбогдох дүгнэлт, тооцоо судалгаанд үндэслэн боловсруулсан байна.

Аймгийн Засаг даргын 2020 оны үйл ажиллагааны тайлан, мэдээг иргэдэд танилцуулах уулзалтыг 26 багийн хүрээнд танилцуулж, мэдээлэл өгч, хөрөнгө оруулалт, их засвартай холбоотой 52 багц арга хэмжээнд давхардсан тоогоор 30006

иргэнээс санал хүлээн авчээ. Ковид цар тахлаас шалтгаалан Орхон аймгийн erdenet.mn нэгдсэн цахим хуудсаар дамжуулан хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх ТАХ-ний санал асуулга авахад 41 иргэнээс гэр бүлийн 1731 хүний төлөөлж 81 санал ирүүлжээ.

Иргэд болон төсвийн шууд захирагчдаас ирүүлсэн 1200 гаруй саналыг аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ нэгтгэн эрэмбэлж, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, саналыг боловсруулсан байна.

2021 онд шинээр хэрэгжүүлэхээр баталсан 139 ТАХ-ний 3 буюу 2.2 хувь нь барилга угсралт, 13 буюу 9.4 хувь нь инженерийн шугам сүлжээ, 36 буюу 25.9 хувь нь барилга, их засварт, 2 буюу 1.4 хувь нь гэрэлтүүлэг, цахилгаан, 12 буюу 8.6 хувь нь авто зам, 55 буюу 39.6 хувь нь тоног төхөөрөмж, 18 буюу 12.9 хувь нь зураг төсөв, зөвлөх үйлчилгээнд төлөвлөсөн байна. Үүнийг дүрслэлээр харуулбал:

Дүрслэл 1. Хөрөнгө оруулалтын төрөл



А.2. Тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, тооцоо судалгаатай ТАХ-г төсөвлөж, батлах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 249 ТАХ-ээс зураг төсөв шаардахгүй 60 ТАХ, өмнөх оноос шилжин хэрэгжих 110 ТАХ, зураг төсөвтэй хэрэгжих 79 ТАХ байх ба 35 ТАХ-г зураг төсөлгүй баталсан байна.

Баталгаажсан зураг, төсөвгүй барилга, байгууламжийн төсөвт өртгийг 2020 онд санхүүжих дүнгээр баталснаар 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд төсөвт өртгийг нэмэгдүүлж баталсан байна. Тухайлбал барилга байгууламжийн төсөвт өртгийг 2,707.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж баталжээ. Үүнд:

- Эрдэнэт Ус ДТС ОНӨХК-ний Захиргааны байр барих – 2,327.3 сая төгрөг,
- Эрдэнэт шинжлэх ухаан технологийн парк ОНӨААТҮГ-ын үйлдвэрлэлийн барилга/ - 255.3 сая төгрөг,
- Хүрэнбулаг баг, 11-р хорооллын Б хэсэгт УДХТ барих – 125.0 сая төгрөг

Төсвийн тухай хуулийн 29.3.5-д шинээр эхлэх ТАХ-ний нийт төсөвт өртгөөс тухайн жилд ногдох хэсэг нь ТАХ-г хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байхаар заасан байтал 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжих 3,000.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 ТАХ-ний тайлант онд санхүүжих дүнг төсөвлөлтийн зарчмыг хангуулахгүй, санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталжээ.

Хүснэгт 3. Санхүүжилтийг хэрэгжих хугацаатай уялдаагүй баталсан төсөл, арга хэмжээ /сая төгрөг/

д/д	ТАХ-ний нэр	хэрэгжих хугацаа		Баталсан		Төсөл арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан байх хэмжээ	Зөрүү /тайлант онд санхүүжих-тэнцүү хуваарилсан байх/
		Эхлэх	Дуусах	төсөвт өртөг	тайлант онд санхүүжих дүн		
1	Уртын гол багт орон сууц төсөл хэрэгжүүлэх	2021	2023	3,000.0	3,000.0	1,000.0	2000.00
	ДҮН			3,000.0	3,000.0	1,000.0	2,000.0

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжих 144 ТАХ-ээс хөрөнгө оруулалтын шинж чанартай бус, Төсвийн тухай хуулийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг” гэж заасантай нийцээгүй 8 ТАХ-нд 81.2 сая төгрөг төлөвлөж баталсан байна. Үүнд:

- Аймгийн ЗДТГ-ын автомашины засварын зардал 9.8 сая төгрөг,
- ХХҮГ-ын дэргэдэх Ахмадын сувиллын дотор засвар 3.5 сая төгрөг,
- Аймгийн музейн засвар /үүдний хэсгийн тохижилт / 7.5 сая төгрөг,
- Эрдэнэт цэцэрлэгт хүрээлэнгийн ашиглалтын өмнөх захиргааны автомашины урсгал засварын зардал 3.5 сая төгрөг,
- Пара таеквондогийн заал тохижуулах зардал 3.0 сая төгрөг,
- ЗДТГ-ын Хууль тогтоомжийн лавлагааны сангийн өрөөнд зориулалтын тавиур хийлгэх 4.0 сая төгрөг,
- Аймгийн 45 жилийн ойн тэмдэг хийлгэх 40.0 сая төгрөг,
- Орхон аймгийн хурал захиргааны байгууллагын үйл ажиллагаатай холбоотой бодлогын баримт бичгийн эмхэтгэл хэвлүүлэх 9.9 сая төгрөг.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын жагсаалтад баталж буй бага өртөг бүхий болон урсгал зардлаар санхүүжүүлэх зардлууд батлахгүйгээр тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх хэрэгцээ шаардлагатай, тооцоо судалгаатай бүтээн байгуулалтын ажлуудад төсөвлөж, батлах шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТ ТОДОРХОЙ ШАЛТГААНААР БҮРЭН ДУУСААГҮЙ Ч САНХҮҮЖИЛТ ОЛГОХ, ХӨРӨНГӨ БҮРТГЭХ АЖИЛЛАГААНД ХЯНАЛТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГАТАЙ БАЙНА.

Б.1 Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулж, хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангуулах шаардлагатай байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжих 441.4 сая төгрөгийн 6 ТАХ-ний худалдан авах, гэрээ байгуулах, санхүүжүүлэх эрхийг Жаргалант сумын ЗДТГ-т шилжүүлсэн байна.

Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ын 2.13-т “захиалагч хуулийн 46.3-т заасны дагуу эрх шилжүүлэх тохиолдолд төсөв батлагдсанаас хойш 60 хоногийн дотор, хэрэв тодотгол орсон бол түүнээс хойш 30 хоногийн дотор тус тус холбогдох албан тушаалтанд шилжүүлсэн байх” гэж заасны дагуу аймгийн Засаг даргын 2020 оны 12 дугаар сарын 17-ны өдрийн А/755, 2021 оны 10 дугаар сарын 04-ний өдрийн А/482 дугаар захирамжаар 6 ТАХ-г хуулийн хугацаанд шилжүүлжээ.

Аймгийн худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний биелэлт 96.5 хувийн гүйцэтгэлтэй бөгөөд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 144 ТАХ-ээс 1 ТАХ-ний зураг төсөв ирээгүй, 4 ТАХ тендер зарлаад амжилтгүй болж, 139 ТАХ-ний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан байна. Үүнээс цахимаар 117, уламжлалт хэлбэрээр 22 ТАХ-г зохион байгуулж, гэрээ байгуулсан байна.

Худалдан авах ажиллагааны 2021 оны төлөвлөгөөний хэрэгжилтийн хугацааг 1-199 хоногоор хэтрүүлсэн байна. Тухайлбал:

- Үнэлгээний хороо байгуулах хугацааг 1-21 хоног хэтрүүлсэн 57 ТАХ,
- Гэрээ байгуулах хугацаанаас 1-199 хоног хэтрүүлсэн 124 ТАХ,
- Тендер хүчинтэй байх хугацааг сунгасан 4 ТАХ.

ХАА-ны төлөвлөгөө хугацаа хоцорсон нь 16 ТАХ үнэлгээний хороо байгуулах хугацаанаас хоцроосноос, 36 ТАХ-ний ХАА амжилтгүй болсноос, 22 ТАХ зураг төсөвгүй баталснаас, 32 ТАХ техникийн тодорхойлолт ирүүлэхгүй байснаас, 3 ТАХ ажлын даалгавар ирүүлэхгүй байснаас, 1 ТАХ нэршил өөрчлөгдсөнөөс, 5 ТАХ оролцогч байхгүйгээс шалтгаалжээ.

Харин тендер шалгаруулалт 2-3 удаа зохион байгуулсан 38 ТАХ байх ба 5 удаа зохион байгуулсан 2 ТАХ байна.

124 ТАХ-ний гүйцэтгэгчийг сонгон шалгаруулахад 15 үнэлгээний хороо байгуулжээ. Үнэлгээний хороонд ажилласан гишүүд худалдан авах ажиллагаагаар мэргэшсэн, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн болон төрийн бус байгууллагын төлөөлөл, аймгийн ИТХ-аас томилсон иргэдийн төлөөллийг оролцуулж, худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангасан байна.

Үнэлгээний хороод нь тендерийн баримт бичгийг Сангийн сайдын баталсан жишиг баримт бичгийн тендерт оролцогчдод өгөх зааварчилгаа, агуулга, гэрээний ерөнхий нөхцөл хэсгүүдийг өөрчилдөггүй, өөрийн эрх хэмжээний хүрээнд тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, үе шатны ажлын хуваарь, урилга зэрэг хэсгүүдэд өөрчлөлт оруулдаг байна.

Тендерийн баталгаа, гэрээний тусгай нөхцөл, техникийн тодорхойлолт, үе шатны ажлын хуваарь, урилга зэргийг холбогдох хууль тогтоомжийн хүрээнд боловсруулсан байна.

Аудитад хамруулж, тулган баталгаажуулалт хийсэн 120 ТАХ-ээс ХАА-г зохион байгуулах болон архивын нэгжийн баримтын бүрдэлтэй холбоотой нийтлэг алдаа байна. Тухайлбал:

- ТБОНӨХБАҮХАТ хуулийн 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсгийн дагуу үнэлгээний хороод архивын нэгж үүсгэсэн баримт бичгийн бүрдэл дутуу буюу дотоод товьёг, баталгааны хуудсыг үйлдсэн албан хаагч баталгаажуулаагүй байна.

- Зарим тендерийн баримт бичгийг баталсан он, сар, өдрийг тэмдэглээгүй нь ТБОНӨХБАҮХАТ хуулийн 19 дүгээр зүйл 19.1 дэх хэсэгтэй нийцэхгүй байна.

Гүйцэтгэчийг сонгон шалгаруулах үнэлгээний хороод урилгыг Монголын мэдээ сонинд нийтлүүлэн, tender.gov.mn болон erdenet.mn цахим хуудсанд байршуулж ил тод, нээлттэй өрсөлдөх боломжоор хангасан байна.

Тендер шалгаруулалттай холбоотой 6 гомдлыг Сангийн Яаманд гаргасан ба дахин үнэлгээ хийж, шалгаруулах заавар чиглэл өгснөөс 3 ТАХ-д тодруулга авч, дахин үнэлгээ хийсэн, 2 ТАХ-д дахин үнэлгээ хийж шаардлага хангасан тендер байхгүй тул хүчингүй болгон тендерийн дахин зарласан, 1 ТАХ-г хүчингүй болгон дахин тендер зарласан байна.

Сангийн яам ТЕЗ-ийн 2021 оны худалдан авах ажиллагааг үнэлээгүй байна.

Аймгийн ОНӨГ нь Орхон аймгийн 2021 оны худалдан авах ажиллагааны тайланг улирал бүр тайлагнаж, erdenet.mn, shilendans.gov.mn болон tender.gov.mn цахим хуудсанд тогтмол мэдээлж хэвшсэн байна.

ТЕЗ-ийн 2021 онд хэрэгжүүлсэн бараа, ажил, үйлчилгээний худалдан авах ажиллагааны тайлан мэдээг аймгийн Засаг даргын 2021 оны 07 дугаар сарын 07-ны өдрийн 01/1381, 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 01/56 дугаар албан бичгээр холбогдох маягтын дагуу гаргаж Сангийн сайдад хугацаанд нь хүргүүлжээ.

Б.2 Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангах нөхцөл, боломжийг олгож, удааширч буй ажлуудад анхаарахаар байна.

Аймгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн 249 ТАХ-ээс 5 ТАХ-ний худалдан авах ажиллагаа амжилтгүй болж, 2022-2023 онд шилжин хэрэгжих 7, бүрэн дууссан 215, хэрэгжиж дуусаагүй 22 ТАХ байх ба хэрэгжилт 88.1 хувь болж өмнөх оны биелэлтээс 1.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 4 Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний гүйцэтгэл

№	ТАХ-ний гүйцэтгэлийн хувь	2021 онд хэрэгжих ТАХ		Нийт ТАХ
		шилжих	шинэ	
1	Бүрэн дууссан	18	197	215
2	Он дамжин хэрэгжих	1	6	7
3	Бүрэн дуусаагүй	10	12	22
	- 0-50 хувийн гүйцэтгэлтэй	2	4	6
	- 51-90 хувийн гүйцэтгэлтэй	8	8	16
	Нийт дүн	29	215	244

ТАХ-ний гүйцэтгэлийн болон санхүүжилтийн баримт материалуудыг тулган баталгаажуулахад зураг төсөв, техникийн тодорхойлолт, ажлын даалгаврын дагуу гүйцэтгэж, холбогдох төрийн байгууллагуудад хүлээлгэн өгсөн байна.

Гэрээний хугацаанд гүйцэтгээгүй ТАХ-үүд нь хил хааж, бараа материалын хомсдол үүссэнээс болон захиалагчийн үйл ажиллагаанаас шалтгаалжээ.

Захиалагч ТАХ гүйцэтгэгчийг хугацаандаа гүйцэтгэх урьдчилсан нөхцөлийг хангуулж, үр дүнтэй гүйцэтгэх боломжийг олгох хэрэгтэй байна.

Захиалагчийн хяналтыг ХББЗА ОНӨААТҮГ, ХЗА, ОНӨГ, зохиогчийн хяналтыг зураг, төсөв гүйцэтгэгч компаниуд хэрэгжүүлсэн бөгөөд Барилгын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.1, 37.1.4, 37.1.5, “Барилгын захиалагчийн хяналтын дүрэм”-ийн 2.2, 3.1.4, 3.4, 3.6, 3.12, 3.14 дэх заалтуудыг мөрдсөн байна.

Аудитын явцад захиалагчийн хяналт хэрэгжүүлсэн ажлын тайлан, холбогдох материалыг санхүүжилтийн баримттай тулган баталгаажуулахад дараах зөрчил илэрлээ. Үүнд:

- БОАЖГ, СГСГЗ-ны байр барихад шаардлагатай ИШС барих – гэрээ байгуулж, ажил хийгээгүй байна.
- Цэцэрлэгт хүрээлэнгийн хөрөнгө оруулалтын ажил – зураг төсөвгүй ажил эхэлсэн боловч ажил хийгээгүй байна.
- Орон сууцны хороолол доторх ногоон байгууламж нэмэгдүүлэх, гэрлэн чимэглэл хийх – техникийн комисс ажиллуулах хүсэлт өгсөн, тарьсан мод ургаагүй, шаардлага биелүүлээгүй байна.
- Хүрэнбулаг баг, 11-р хорооллын Б хэсэгт УДХТ барих – ажлаа бүрэн дуусгаж хүлээлгэж өгөөгүй байна.
- Баянцагаан багийн ИШС-ний зураг төсөв – бүрэн дуусаагүй байна.

Иймд эдгээр 5 ТАХ-ний хэрэгжилтийг хангуулах асуудлыг шийдвэрлэх албан шаардлагыг аймгийн Засаг даргад хүргүүлэв.

Захиалагчийн хяналт хэрэгжүүлж буй ХББЗА ОНӨААТҮГ-ын хяналтын үр нөлөөгөөр дуусаагүй ажил өмнөх оноос буурсан ч үр дүнг сайжруулж, эрх бүхий албан тушаалтнаар асуудлыг тухай бүр шийдвэрлүүлэхээр байна.

Аймгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлсэн 248 ТАХ-г гүйцэтгэх явцад захиалагч, зураг төсөв зохиогч, холбогдох мэргэжлийн байгууллагаас хэрэгжүүлсэн хяналт, түүний гүйцэтгэл, зөрчил дутагдлын биелэлтийг хэрхэн хангуулсан эсэхийг талбайн журнал, холбогдох бусад баримт материалын хүрээнд тулган баталгаажуулав.

Барилга байгууламжийн талбайн журналд тэмдэглэснээр ТАХ-ний хэрэгжилтийн явцад хяналтын инженерүүд, зураг төсөв зохиогчид хөдөлмөр хамгааллын дүрмийг сахиж ажиллах, үе шатны ажлыг технологийн дагуу хугацаанд нь гүйцэтгэх, дутуу болон чанаргүй хийгдсэн ажлыг дахин хийх, үе шатны ажлыг гүйцэтгэж дуусахад актуудыг холбогдох албан тушаалтнуудаар заавал баталгаажуулж байх, бараа материалын гарал үүслийн баримт бичиг, баримтыг орчуулж, сорьц дээжийг лабораторид шинжлүүлэх гэх зэрэг үүрэг даалгавар, зөвлөмжийг өгч ажилласан байна.

Захиалагчийн хяналтыг холбогдох хууль, дүрэм, журмын дагуу хэрэгжүүлж, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээг авч, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг гүйцэтгэгч байгууллагууд хэрэгжүүлж, ил далд ажлын акт үйлдэн, захиалагч, зохиогч нараар хянуулж, фото зургаар баталгаажуулсан байна.

Мөн графикт ажлыг хугацаанд нь гүйцэтгэх, гэрээнд заасан хугацаанд багтаан дуусах зэргээр ахиц гарсан байх ба удааширсан ТАХ-ний гэрээг цуцлах саналыг захиалагчид хүргүүлж, шийдвэрлэлт удааширчээ.

Илэрсэн зөрчлийг гүйцэтгэгчээр тухай бүрд нь арилгуулах арга хэмжээг авч, тодорхой үр дүнд хүрсэн хэдий ч удааширч буй ажлуудад анхаарахаар байна.

Б.3 Хөрөнгө оруулалтын ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу олгож байгаа ч холбогдох дансанд хяналт хэрэгжүүлээгүй, хөрөнгийг дутуу бүртгэжээ.

Аймгийн ИТХ-ын 2020 оны 02/05, 2021 оны 07 дугаар тогтоолоор аймгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжих 45,212.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй, 249 ТАХ-ний 2021 онд санхүүжих дүнг 29,579.2 сая төгрөг байхаар баталсан.

2021 онд олгохоор баталсан 29,579.2 сая төгрөгийн санхүүжилтээс гүйцэтгэгч байгууллагад 24,451.5 сая төгрөг буюу 82.7%-ийг гүйцэтгэлийг үндэслэн олгож, магадалшгүй ажил, техник хяналт, зураг төсөв, барьцаанд 1,780.9 сая төгрөгийг суутгасан байна.

Санхүүжилтийг гэрээнд тусгасны дагуу баталгаажсан барилга угсралт, их засварын ажлын гүйцэтгэлийг үндэслэн олгосон байна.

Санхүүжилт олгохдоо ТАХ бүрээр баталгаажсан ажлын гүйцэтгэлээс суутгах захиалагчийн болон зохиогчийн хяналтын зардал, зураг төслийн үнэ, чанарын баталгаат хугацааны барьцааг суутгахгүйгээр оны эцсээр буюу 10-12 сард нэгтгэж, жагсаалт тооцоо үйлдэхгүйгээр шилжүүлжээ.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын барьцаа, техник хяналтын зардлын 7,759.5 сая төгрөгийн, орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн ТАХ-ний санхүүжүүлээгүй үлдэгдэл 5,127.7 сая төгрөгийн үлдэгдлийг ТАХ хэрэгжүүлэгч бүрээр өгөх өглөг болон шилжих үлдэгдлийн дүнг нэгтгэж дэлгэрэнгүй тайлагнаагүй бөгөөд түүнд үр дүнтэй хяналт хэрэгжүүлээгүй байна.

ТАХ-ний санхүүжилтийг бодит гүйцэтгэлээр олгож байгаа ч холбогдох дансанд хэрэгжүүлэх хяналт хангалтгүй байна.

Захиалагч барилга байгууламж болон их засварын ажлын хувьд уг ажлыг дуусах хүртэл хугацаанд, тоног төхөөрөмжийн хувьд хүлээн авсан эцсийн гүйцэтгэлийн дүнгээр эргэлтийн хөрөнгөд бүртгэдэг байна.

Аймгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2021 онд хэрэгжсэн 244 ТАХ-ээс орон нутгийн өмчийн бүртгэлд бүртгэж, тайлагнасан эсэхийг ТАХ-ний гүйцэтгэлтэй тулгахад 235 ТАХ бүрэн дуусаж өмчид бүртгэхээр, 9 ТАХ-г дуусаагүй барилгад бүртгэхээр байна. Эдгээрээс 2021 онд хэрэгжиж дууссан 36,424.5 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 204 ТАХ-г бүртгэсэн бөгөөд дуусаж хүлээн авсан 5 зураг төсвийн 344.2 сая төгрөгийг бүртгээгүй байна. Бүртгээгүй ТАХ-г бүртгэх албан шаардлага хүргүүлэв.

Хөрөнгө бүртгэх явцад өмнөх оны аудитаар дуусаагүй барилгад дутуу бүртгэсэн хөрөнгийн бүртгэх албан шаардлага хүргүүлснийг тухайн данснаас холбогдох шийдвэргүйгээр хөрөнгө орлого, зарлагаар бүртгэж залруулжээ.

Зарим ТАХ-ний хувьд баримт бичгийн бүрдүүлбэрийг хангуулах, хянах, холбогдох зөвшөөрөл авах, захирамж гаргах зэргээр 2022 онд бүртгэхээр байна. Хөрөнгө оруулалтын ажлыг бүртгэх, ашиглалт, хамгаалалтыг хариуцах, өмнөх оны алдаа давтагдан гарсаар байгаа нь төсвийн хөрөнгийн ашиглалт хангалтгүй байх, хөрөнгө алдагдах эрсдэлийг үүсгэхээр байна.

Нийлүүлсэн техник, тоног төхөөрөмж, ашиглалтад хүлээн авсан барилга байгууламжийн ашиглалтыг тулгахад 2018-2020 онд ашиглалтад орсон боловч зориулалт, хүчин чадлын дагуу ашиглаагүй 6 барилга байгууламж байгаа бөгөөд хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна. Тухайлбал:

- Дэнж багт ухаалаг худаг, 2018 он
- Оюуны спортын ордон, 2018 он
- Говил багийн Тахилтын худаг, 2019 он
- Эрдэнэ багийн 49-р гудамжны худаг, 2019 он
- Байцааны /505 тн/ зоорь, 2019 он

- Яргуйт баг, Хөтлийн хэсэгт худаг, 2020 он

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар бүрэн хэрэгжсэн ТАХ-г бүрэн бүртгэх, хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулахад анхаарч, төрийн болон орон нутгийн байгууллагуудыг бодлого арга зүй хангаж, үр дүнтэй хяналт хэрэгжүүлж, албан хаагчдын хариуцлагыг сайжруулах шаардлагатай байна.

Б.4 Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Өмнөх онд хийсэн аудитаар аймгийн ИТХ, аймгийн Засаг даргад зөрчил арилгуулахаар нийт 1,468.8 сая төгрөг 5 зөвлөмж, 5,502.6 сая төгрөгийн 4 албан шаардлага хүргүүлснээс 1 зөвлөмж бүрэн хэрэгжээгүй байна. Тухайн үед хэрэгжилтийг тулгахад бүрэн хэрэгжсэн хэдий ч зарим албан шаардлага, зөвлөмжөөр өгсөн зөрчлүүд давтан гарсаар байна. Үүнд:

- Худалдан авах ажиллагаатай холбоотой гомдол өмнөх оноос буураагүй нь үнэлгээний хорооны гишүүдийн ур чадвар, үйл ажиллагааг сайжруулахаар байгааг илтгэж байна.
- Гүйцэтгэгчтэй байгуулсан гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангуулах, хангагдахгүй шалтгаан үр дагаврыг хэлэлцэн шийдвэрлэж, чанаргүй, дутуу гүйцэтгэдэг аж ахуйн нэгжийн судалгааг гаргаж, холбогдох хяналтын байгууллагуудаар тодорхойлуулж байгаа боловч шийдвэрлэлт удаан, үр дүн гараагүй байна.
- Зураг, төсвийн ТАХ-г орон нутгийн хөрөнгөд бүртгээгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Аймгийн хөрөнгө оруулалтыг нэгдсэн бодлогын хүрээнд төлөвлөж байна.
- Тэргүүлэх ач холбогдолтой, зайлшгүй хэрэгжүүлэх шаардлагатай, тооцоо судалгаагаар ТАХ-г төсөвлөж, батлах шаардлагатай байна.
- Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны гишүүдийг чадавхжуулж, хууль, журмын хэрэгжилтийг бүрэн хангуулах шаардлагатай байна.
- Захиалагч гэрээний хэрэгжилтийг хугацаанд нь бүрэн хангах нөхцөл, боломжийг олгож, удааширч буй ажлуудад анхаарахаар байна.
- Хөрөнгө оруулалтын ТАХ-ний санхүүжилтийг гүйцэтгэлийн дагуу олгож байгаа ч холбогдох дансанд хяналт хэрэгжүүлээгүй, хөрөнгийг дутуу бүртгэжээ.
- Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлсэн боловч алдаа зөрчлийг давтан гаргасан байна.

Аудитаар нийт 30,514.0 сая төгрөгийн зөрчил илэрснээс 344.2 сая төгрөгийн зөрчилд 2 албан шаардлага, 30,169.8 сая төгрөгийн 6 зөвлөмж хүргүүллээ.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн ИТХ-ын дарга Д.Мөнхбат-д

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар бий болсон хөрөнгийн ашиглалтад анхаарч, үр ашиггүй, төсөвлөлтийн шаардлага хангахгүй хөрөнгө оруулалт төлөвлөхгүй байх талаар ИТХ-ын төлөөлөгч нар болон намын бүлгүүдийг мэдээллээр хангаж, үр нөлөөг сайжруулах.

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д

- Орон нутгийн хөрөнгө оруулалтаар ашиглалтад хүлээн авсан ашиглахгүй байгаа хөрөнгийн ашиглалтад онцгой анхаарч, үр ашиггүй хөрөнгө оруулалт төлөвлөхгүй байх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т

- Орон нутгийн ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн ТАХ-ний үлдэгдэл, техник хяналтын зардал болон барьцааны дансны өглөгийг данс нээгдсэн оноос эхлэн ТАХ хэрэгжүүлэгч бүрээр гарган баталгаажуулж, хяналт хэрэгжүүлж ажиллах;

Аймгийн ОНӨГ-т

- Үнэлгээний хорооны ажлын гүйцэтгэлийн баримт бичгийн бүрдэлд анхаарч, хяналт хэрэгжүүлэх;
- Орон нутгийн өмчийн хөрөнгөд бүртгэлтэй дуусаагүй барилга, байгууламжийг Засаг даргын захирамж шийдвэргүйгээр зарлагаар бүртгэхгүй байх, албан хаагчдын хариуцлагыг дээшлүүлэх;

ХББЗА ОНӨААТҮГ-т

- 2021 онд ашиглалтад орох ёстой 17,282.6 сая төгрөгийн 25 ТАХ-ний хэрэгжилтийг 2022 оны 09 дүгээр 01-ний дотор хангуулж, ашиглалтад хүлээн авах;

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Холбогдох байгууллагын санал:



**МОНГОЛ УЛС
ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА**

61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг,
Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон
Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621
И-мэйл: info@erdenet.mn

2022. 05. 06. № 01/1094
танай _____-ны № _____-т

**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАРТ**

“Улсын төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн, үр ашиг”, “Орон нутгийн төсвийн 2021 оны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн”-д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлд өгөх санал байхгүй болно.

Аудитын дүн, дүгнэлтээр өгсөн зөвлөмж, албан шаардлагыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж, цаашид анхаарч ажиллах болно.

ЗАСАГ ДАРГА

С.БАТЖАРГАЛ



Б.Навзмаа

Батлан хуулиаар

М. 4706

D:/My documents/A-5 doc

6122020665

Саналд өгсөн тайлбар: Аудитаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.